



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн өргөн
чөлөө 3, Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101

Утас: (976) 70442273

Цахим шуудан: info@bayankhongor.gov.mn

Цахим хаяг: www.bayankhongor.gov.mn

2022. W. W № 8/17/6

танай _____ -ны № _____ -т

Г УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 7
ДАРГА Ц.МӨНХЖАРГАЛ ТАНАА

Аймгийн Засаг даргын 2022 оны A/286 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг дүгнэсэн илтгэх хуудас, зөвлөмжийг хүргүүлж байна.

Зөвлөмжийг хяналтад авч хэрэгжилт хангалтгүй байгаа ажлуудад анхаарлаа хандуулан бодит үр дүнд хүргэж ажиллана уу.

Хавсралт..Х.хуудастай.



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

ell *and* *l.MANDAL*

652212239

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ИЛТГЭХ ХУУДАС

Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны эхний хагас
жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ,
үнэлгээ хийсэн тухай

2022 оны 07 дугаар сарын 22

Номгон

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Төрийн болон орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэх, зөрчил, дутагдлыг засч, залруулах, шийдвэр гаргах үйл ажиллагааг бодит байдал, нотлох баримтад тулгуурласан байхад чиглүүлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх, нэгдсэн бодлого, зөвлөмжөөр хангах зорилгоор Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Үнэлгээг аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчтэй байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг (Цаашид “журам” гэж хэрэглэх) удирдлага болгон 2022 оны эхний хагас жилийн тайлангийн хэрэгжилтийг зорилтот түвшинд хүрсэн эсэхэд дүн шинжилгээ хийж, үнэлсэн болно. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг үнэлэхдээ зүйл, заалтын агуулга жил бүр давтагдах шинж чанартай бол тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын үр дүнгээр, нэг удаагийн үйлчлэлтэй бол шийдвэр гарсан өдрөөс хойш хэрэгжүүлсэн үйл ажиллагааны өссөн дүнгээр үнэлгээг тооцож гаргалаа.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ:

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд журмын нэгдүгээр хавсралтаар батлагдсан цаглавраар тайлагнасан дараах баримт бичгүүдийг хамруулсан. Үүнд:

- 1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт;
- 2.Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлт;
- 3.Дэд хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт;
- 4.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт;
- 5.Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт;
- 6.Байгууллагын гүйцэтгэлийн тайлан;
- 7.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлт;

8. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ;

9. Засгийн газрын зарим чиг үүргийн орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт;

10. Шилэн данс хөтлөлтийн үнэлгээ;

11. Архив, албан хэрэг хөтлөлтийн үнэлгээ;

12. Байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой шалгуур үзүүлэлтийн үнэлгээ;

Тус байгууллага Баянхонгор аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системээр Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлт, Дэд хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт, Байгууллагын гүйцэтгэлийн тайлан, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлт тайлангуудыг хугацаа хоцроосон, Ил тод байдлын үнэлгээ, Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт зэрэг 9 тайланг тайлагнахаас Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлт, Дэд хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, аймгийн Засаг даргын захирамж, шийдвэрийн биелэлтүүдийг хугацаа хоцроож, Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн:

Байгууллагын 2022 оны эхний хагас жилийн тайлангуудад хийсэн үнэлгээ, үр дүн, цаашид анхаарах асуудлыг тайлан тус бүрээр танилцуулья.

Нэг. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй 4 зорилт, 6 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд үр дүнтэй буюу 100% -3, 90% -1, тодорхой үр дүнд хүрсэн 70% -2, дундаж 88.33% -тай дүгнэгдлээ.

Жич: Үнэлгээг <https://bayankhongor.igovernment.mn/provinceplan/> -цахим сангаас үзэх.

Хоёр. Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлт:

Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний 1 арга хэмжээг хэрэгжүүлсэн, 70 хувийн хэрэгжилттэй байна.

Гурав. Дэд хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:

Улсын бүртгэлийн хэлтэс нь 3 дэд хөтөлбөрийн 4 арга хэмжээг хяналтад авч

хэрэгжилт тооцсон тайланд үнэлгээ хийхэд хэрэгжилт 70 хувьтай байна. Үүнээс 4 арга хэмжээ 70-100% буюу Тодорхой үр дүнд хүрсэн гэж үнэлэгдсэн.

Цаашид бодит үр дүнг нэмэгдүүлж ажиллах;

Дөрөв.Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Тус хэлтэс 7 хууль, тогтоомжийн 7 заалтыг хэрэгжүүлж, тайлагнаасаас бүрэн хэрэгжсэн 100 хувьтай 1, хэрэгжих шатандаа байгаа 4, хэрэгжээгүй 2 заалт байна. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 54.29 хувьтай байна.

Хууль тогтоомжийн заалтын агуулгыг бүрэн тайлагнаагүй, тайлангийн шаардлага хангаагүй хэрэгжилтийн үнэлгээг журмын 5.5-ыг үндэслэн бууруулсан. Тухайлбал: Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг тайлагнахдаа Хүйсийн тэнцвэрт байдлын тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн эсэхийг тайлагнах ёстой байхад “Хэрэгжилтийг гаргаж хугацаанд нь хүргүүлсэн.” гэж тайлагнасан. Үнэлгээг <https://bayankhongor.igovernment.mn/provinceplan/> -цахим сангаас үзэх.

Цаашид анхаарах асуудал:

Хэрэгжилтийг журмын дагуу эрх зүйн актын заалт нэг бүрийн доторх агуулгын гүйцэтгэлийг оновчтой, товч тодорхой, иж бүрэн, нотлох баримттай тайлагнаагүйгээс тайлангийн үнэлгээ буурч байгаа тул тоо баримттай, зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр, суурь түвшинтэй харьцуулсан байдлаар тайланд тавигдах шаардлагыг ханган тайлагнах, бодитой үнэлэх;

Тав.Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт:

Улсын бүртгэлийн хэлтэс нь 5 шийдвэрийн 20 заалтын хэрэгжилтийн тайланг ирүүлснээр хэрэгжилт 80 хувьтай үнэлэгдлээ. Үүнээс 8 заалт 100% буюу бүрэн хэрэгжсэн, 11 заалт хэрэгжих шатанд буюу 70%, 1 заалт хэрэгжилт хангалтгүй буюу 30% гэж үнэлэгдсэн байна.

Захирамжийн хэрэгжилтийг үнэлэхдээ зорилтот түвшинд хүрээгүй, тайланд тавигдаж буй шаардлагыг хангаагүй, нотлох баримтыг хавсаргаагүй дараах захирамжуудын үнэлгээг журмын 5.2, 5.4, 9.3 дахь хэсгийг үндэслэн бууруулсан. Үүнд:

- Аймгийн "Хонгорын гэр бүл арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөг батлах тухай" 2022 оны А/265 дугаар захирамж;
- Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай 2022 оны А/57дүгээр захирамж;

➤ Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах, бүтээмжийг нэмэгдүүлэх тухай 2022 оны 03 дугаар албан даалгавар;

Цаашид захирамж, шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэхэд санаачлагатай ажиллах;

Зургаа.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Улсын бүртгэлийн хэлтэс 2022 оны гүйцэтгэлийн тайлан, төлөвлөгөөнөөс зөрүүтэй тайлагнагдсан. Шинэчлэн батлуулсан төлөвлөгөөний хувилбарыг авч ирснээр үнэлгээ хийгдсэн. Тус хэлтэс 8 зорилт, 49 арга хэмжээтэй төлөвлөсөн байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөө 82.2 хувьтай хэрэгжсэн байна.

Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	49
Бүрэн хэрэгжсэн 100% (90-100)	26
Хэрэгжих шатанд 70% (50-90)	14
Хэрэгжилт хангалтгүй 30% (10-50)	5
Хэрэгжээгүй 0% (0-9 хувь)	1
Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	3
Нийт	49
Дундаж	82.2

Гүйцэтгэлийн тайланг гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй тулгаж, үр дүнг хянан үзээд:

- Зорилtot түвшин, шалгуур үзүүлэлтийг буруу тодорхойлсон: 1.1;
- Зорилtot түвшинд хүрээгүй, үр дүн тодорхойгүй байдлаар тайлангийн шаардлага хангахгүй тайлагнасан хэрэгжилтийг 100 хувь гэж үнэлсэн 5 4.2; 5.6 арга хэмжээнүүдийн үнэлгээг бууруулсан.

Цаашид анхаарах асуудал:

1.Төлөвлөгөөнд Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолыг баримтлан төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг тусган хэрэгжүүлэх;

2.Жилдээ хэрэгжих арга хэмжээний зорилtot түвшинг эхний хагас жилд, сүүлийн хагас жилд гэж ялгаатай тодорхойлох;

3.Аймгийн Засаг даргаар батлуулсан төлөвлөгөөг өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст нэг хувийг өгөх;

Долоо.Байгууллагын шалгуур үзүүлэлтийн үнэлгээ:

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь		Тайлант он /2022 оны хагас жил/	Үнэлгээ
		Түвшин	Он		
1	2	3	4	5	6
Бүртгэлийн үйлчилгээг хуульд заасан хугацаанд, алдаа зөрчилгүй, иргэдэд хөнгөн шуурхай үзүүлж, ажилласан байх	тоо	11526	2021	12893	100
Бүртгэлийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчилсан байдал, тоо, үр дүн	тоо	25	2021	38	100
Иргэдийн өргөдөл, гомдолын шийдвэрлэлт	тоо	71	2021	64	80
Нийт үнэлгээ					93.33

Байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой шалгуур үзүүлэлтийн үнэлгээг тус агентлагаас ирүүлсэн тайланд үндэслэн дүгнэж, Шилэн данс, Архив, албан хэрэг хөтлөлтийн үнэлгээг журмын дагуу холбогдох байгууллагуудаас авч нэгтгэсэн.

Цахим тайлангийн дэлгэрэнгүй үнэлгээ, зөвлөмжийг Баянхонгор аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний <https://bayankhongor.igovernment.mn/> цахим системээс харах боломжтой.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны үнэлгээний дүн, Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх тухай зөвлөмжийг тус тус хавсаргав.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН ДАРГА

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.МАНДАЛ

Б.БУЛГАМАА



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

1	2	Хувь	Жин	Оноо
		3	5	6
Бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт (хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хамт)	88.33	0.5	
	2.Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлт	70.00		
	3.Дэд хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	70		
	4.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	54.29		
	5.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт	-		
	6.Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Засаг даргын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт	80		
	7.Зөвлөмжийн хэрэгжилт	-		
	8.Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	-		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт	-	0.3	
	2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	82.17		
	3.Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт	-		
	4.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлт	78.57		
	5.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	98.04		
	6.Тухайн жилд дэвшиүүлсэн зорилтын хэрэгжилт	-		
	7.Шилэн данс	-		
	8.Архив, албан хэрэг хөтлөлтийн үнэлгээ	50		
	9.Хэрэглэгчийн үнэлгээ	-		
Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ	1.Ногоон байгууламж (Мод тарих)		0.2	
	2.Цахим шилжилт			
	3.Байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой шалгуур үзүүлэлтийн үнэлгээ	93.3		
	Ерөнхий үнэлгээ:	76.5		1
Хугацаа хоцорсон тайлан /-2/	Хоцроосон тайлан 4*2	68.5		

.....оо.....



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС
ЗӨВЛӨМЖ

2022 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 25

Номгон

Г Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайлангийн үр дүнг нэмэгдүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэх, зөрчил, дутагдлыг засч, залруулах, шийдвэр гаргах үйл ажиллагааг бодит байдал, нотлох баримтад тулгуурласан байхад чиглүүлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх, нэгдсэн бодлого, зөвлөмжөөр хангах зорилгоор Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах зөвлөмжийг өгч байна.

Нэг.Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд:

1.Хэрэгжилт хангалтгүй хууль тогтоомжийг хяналтад авч, хэрэгжилтийг нэмэгдүүлэх:

-Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай -Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоол;

-Засгийн газрын 2022 оны 2 дугаар сарын 23-ны өдөр 12 дугаар тэмдэглэл;

2.Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022 оны 7 дугаар тогтоолын заалт нэг бүрийг хэрэгжүүлэх, Монгол хэлний тухай хуулийн дагуу албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах;

Хоёр.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай илтгэх хуудас болон bayankhongor.igovernment.mn цахим хуудасны тайланд тэмдэглэсэн алдаа, дутагдлыг засах, дахин давтахгүй байх, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах;

2.Хууль, тогтоомжийг бүрэн хяналтад авч хугацаа алдалгүй хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах;

3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилтот түвшинг шалгуур үзүүлэлтийн дагуу өссөн үр дүнг илэрхийлсэн байхаар эхний хагас жилд, сүүлийн хагас жилд хүрэх түвшин гэж ялгаатай тодорхойлох, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааны төлөвлөгөөг хамтад нь батлуулан хэрэгжүүлэх, бодитой төлөвлөх;

4. Аймгийн Засаг даргаар батлуулсан төлөвлөгөөг бүрэн тайлагнах, өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст нэг хувийг өгөх;

5. Хэрэгжилтийг тайлагнахдаа бодлогын бичиг баримт, эрх зүйн актын заалт нэг бүрийн доторх агуулгын гүйцэтгэлийг тоо баримттай, зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр, суурь түвшинтэй харьцуулсан байдлаар хэрэгжилтийн явцыг бус үр дүнг товч, тодорхой, алдаа мадаггүй, бодитой, итгэл, үнэмшил төрүүлэхүйц, иж бүрэн, нотлох баримттай тайлагнах;

6. Аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан журмыг баримтлан бодитой үнэлж, цаг хугацаанд нь тайлагнах;

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 12 дугаар сарын 30-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлэх;.

